



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 108

Хэрлэн сум

Салбар комисс байгуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.2.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 3.5, 3.5.3, 2023 оны “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай” 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.1, 6.5-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулах салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Салбар комиссын

дарга: Б.Дарханбаатар Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн

дарга: Ж.Саруултөгс Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

Б.Сүнгээ Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Г.Сэдэдмаа Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Статистикийн хэлтсийн дарга

С.Бат-Эрдэнэ Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

2. Салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Төрийн албаны ерөнхий шалгалтыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, дүнг танилцуулахыг салбар комиссын бүрэлдэхүүнд даалгасугай.

4. Төрийн албаны ерөнхий шалгалтын тайланг хугацаанд нь Төв комисст хүргүүлэхийг нарийн бичгийн дарга /Ж.Саруултөгс/-д даалгасугай.

ДАРГА

Ж. ГАНТУЛГА



Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн
2023 оны 09 дугаар сарын 18-ны өдрийн
108 дугаар тогтоолын хавсралт



ТУСЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Мэдээлэл технологийн
ажилтан:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Компьютерийн технологи, програм
хангамж хариуцсан мэргэжилтэн

Туслах ажилтан:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн мэргэжилтэн

Онцгой байдлын газрын төлөөлөл

Цагдаагийн газрын төлөөлөл

Улсын бүртгэлийн хэлтсийн төлөөлөл

Тагнуулын хэлтсийн төлөөлөл

Эрүүл мэндийн газрын төлөөлөл /эмч,
ЗӨСТ-ийн ажилтан гэх мэт/

БЗӨБЦТС салбарын төлөөлөл